

Н.Золжаргал: Шатахууны үнийн өсөлт нь валютын ханшнаас болоогүй гэдгийг баттай хэлнэ.

Өнөөдөр Ардчилсан намын бүлгийн хуралдаанд Монголбанкны захирлууд валютын ханш яагаад өсөөд байгаа талаар тайлбар өглөө. Ингээд сэтгүүлчдэд хаалттай болсон хуралдааны дараа Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргалаас зарим зүйлийг тодруулсан юм.

-Шатахууны үнэ өссөнийг ам.долларын ханш өссөнтэй холбон тайлбарлаж байна. Энэ дээр танай банкнаас ямар тайлбар өгөх вэ?

-Мэдээж импортын барааны үнэ ханш валютаас хамааралтай. Гэхдээ нэг зүйлийг маш сайн санах хэрэгтэй. Ханш хоёрхон жилийн өмнө 1450 байхад, бензин 1200 байсан шүү дээ. Өнөөдөр гэтэл ам.доллар 1450 л байна. Яагаад 1450 байна гэхээр Монгол улсын гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн жил бараг бүтэн “хасах” явлаа шүү дээ. Бид энэ талаар сар бүр мэдээлж байсан. Оны төгсгөл рүүгээ багасах хандлага гарсан. Нэгдүгээр сарын эхээр мэдээж валютын орлого багасдаг. Энэ хугацаанд ханш бага зэрэг буюу хоёр хувиар өссөн. Арваннэгдүгээр сар болон арванхоёрдугаар сард ханш долоон хувийн хөдөлгөөнтэй байсан.

Гэхдээ үүнээс үүдэлтэй шатахууны үнэ ингэж өндөр өснө гэдгийг сайн ойлгохгүй байна. Ямар ч байсан шатахууны үнийн өсөлт ханшнаас болоогүй гэдгийг би баталгаатай хэлж чадах байна. Яагаад валютын ханшинд буруугаа чихээд байгаагийн шалтгааныг нь сайн ойлгохгүй байна. Гадаад нөхцөл байдал нь өөрчлөгдсөн юм уу гэхээр дэлхийн зах зээл дээр 15 хувийн л өөрчлөлттэй байна. Энэ хооронд онцгой албан татварыг нь тэглэсэн байна.

-Монголбанк одоо ямар алхам хийх вэ?

-Монголбанк арваннэг, арванхоёрдугаар сар, нэгдүгээр сард валютын ханшийг тогтворжуулахын тулд интервенцүүдийг хийж ирсэн, хийж ч байгаа, хийх ч болно. Хятадын цагаан сар манайхаас түрүүнд болж байгаа учир 14 хоног хил хаадаг. Энэ хугацаанд эрэлт үүсч байна. Үүнд зориулаад бид валютын нийлүүлэлтээ мөн нэмсэн. Энэ нийлүүлэлт тогтмол хийгдэж байдаг зүйл. Энэ зах руу хэрэгцээтэй үед нь бид нийлүүлсээр байх болно. Тийм валютын нөөц хангалттай, эх үүсвэр ч хангалттай байгаа. Өнөөдөр гэхэд л ам.долларын ханш 1430 болсон байна.

-Монголбанк өнгөрсөн онд алдагдалтай ажилласан учраас, валютын ханш өсөхөд нөлөөлсөн гэх яриа байна?

-Валютын ханшийн өсөлтөнд Монголбанкны алдагдал ямар ч хамааралгүй. Үүнийг би хариуцлагатайгаар мэдэгдэж байна. Оны төгсгөлд

Монголбанкын валютын орох гарах урсгал буурсан байсан. Үүний үр дүнд л ханшинд өөрчлөлт гарсан. Энэ бол зах зээлийн өөрийнх нь хөдөлгөөн шүү дээ.

-Удахгүй цагаан сараас өмнө сая төгрөг иргэдэд тараана гээд байгаа. Гэтэл шатахууны үнэ нэмэгдэж, дагаад бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх хандлагатай боллоо. Цаашид яах вэ?

-Наад зүйлс чинь бүгдээрээ л нөлөөлнө. Монголбанк ханшаа тогтвортой барих, огцом хөдөлгөөн гаргахгүй байх тал дээр л анхаарч ажиллана.